



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/175

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV/01 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ойн сангийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилтын хүрээнд “Хожуул” төслийг хэрэгжүүлэх зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.


2.Хожуул төслийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах эрхийг Сэлэнгэ сумын Засаг дарга (Б.Ууганбаяр), Бугат сумын Засаг дарга (Х.Ууганбаяр), Хангал сумын Засаг дарга (М.Төмөрбат), Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин), Хишиг-Өндөр сумын Засаг дарга (Н.Мөнхгэрэл) нарт шилжүүлсүгэй.

3.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх талбайн тусгаарлалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг сайтар хангаж ажиллахыг дээрх сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Дээрх ажилд шаардлагатай 75,000,000 (далан таван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын “Хожуул” төслийг хэрэгжүүлэх” (Бугат, Хангал, Орхон, Хишиг-Өндөр, Сэлэнгэ сум) арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

5.“Хожуул” төслийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, явцын хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010132

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 22-ны өдрийн А.176 дугаар
захирамжийн хавсралт

“Хожуул” төслийг хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн зардлын хуваарь

Д/д	Ажлын нэр төрөл	Батлагдсан төсөвт өртөг /мян.төг/	Эрх шилжүүлсэн сумын Засаг даргын нэр
1	2	3	4
1	“Хожуул” төслийг хэрэгжүүлэх /Сэлэнгэ сум/	15,000.0	Б.Ууганбаяр
2	“Хожуул” төслийг хэрэгжүүлэх /Бугат сум/	15,000.0	Х.Ууганбаяр
3	“Хожуул” төслийг хэрэгжүүлэх /Хангал сум/	15,000.0	М.Төмөрбат
4	“Хожуул” төслийг хэрэгжүүлэх /Орхон сум/	15,000.0	Н.Амартүвшин
5	“Хожуул” төслийг хэрэгжүүлэх /Хишиг-Өндөр сум/	15,000.0	Н.Мөнхгэрэл
	Нийт	75,000.0	